

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

### Хянан шалгах түр хороо байгуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийг “Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах асуудал” байхаар тогтоосугай.

2. Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын хүрээ хязгаарыг доор дурдсанаар тогтоосугай:

1/зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг батлах журам, түүний өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал;

2/зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт дах эмийн чанар, аюулгүй байдал, хүртээмж, хяналт баталгаажуулалтын нөхцөл байдал;

3/зах зээл дээр худалдаалагдаж буй зайлшгүй шаардлагатай эмийн үнийн өсөлтийн бодит шалтгаан нөхцөлийн талаар;

4/зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт дах эмийн хүртээмж, тулгамдаж буй асуудал

3. Монгол Улсад эмийн хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах эсхүл хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй болгох саналыг Улсын Их Хуралд танилцуулсугай.

4. Хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Олонхын бүлгийг төлөөлөн:

.....

Улсын Их Хурлын гишүүн

Цөөнхийн бүлгийг төлөөлөн:

.....

Улсын Их Хурлын гишүүн

5.Улсын Их Хурлаас хугацааг сунгаснаас бусад тохиолдолд Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо нь энэ тогтоол баталсан өдрөөс хойш 6 сарын дотор хяналт шалгалт явуулж тайланг санал, дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд танилцуулсугай.

6.Энэ тогтоолыг 2023 оны ... дугаар сарын ... өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг